

ХОТОНТ СУМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛУУДЫН БҮРТГЭН БАРИМТЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын хамгаалалтын захиргаа, Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ, Соёлын төвтэй хамтран 2019 оны 10-р сарын 16-ноос 10-р сарын 20-ны хооронд Хотонт сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын мониторинг тандан болон археологийн хайгуул судалгаа явуулж, Монгол улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баримтжуулалтыг сайжруулахад арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаа.




Зураг 1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт, хайгуул судалгааны ажлын явц.



Зураг 2. Шинээр илрүүлсэн Буган чулуун хөшөө (Навт).

Хотонт сумын үл хөдлөх дурсгалуудын бүртгэл мэдээллийн сангийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, 214 гэрэл зураг, 30 гаруй минутын дүрс бичлэгээр баяжуулж, хамрах хүрээ, нягтаршилыг тодорхойлж газарзүйн байршлыг харуулсан зураглал боловсруулан ЗДТГ, Соёлын төвд хүлээлгэн өгөв.



Зураг 3. Хотонт сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын нисдэг камераар хийсэн дүрс бичлэг.



Зураг 4. Судалгааны ажлын тайлан болон бусад материалуудыг хүлээлгэн өгч буй байдал.